ХӨСӨГ ТРЕЙД

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
# ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр дугаар 08 Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын компанийн тухайн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 88 дугаар зүйлийн 88.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.32.16 дахь заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Милко” ХХК болон “Хаан Банк” ХК хооронд байгуулсан 2024 оны 04-р сарын 01-ний өдрийн №ЗГ24/8 тоот 25,000,000,000 /хорин таван тэрбум/ төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийн эрхийн дүнг 20,262,400,000 / хорин тэрбум хоёр зуун жаран хоёр сая дөрвөн зуун мянган/ төгрөг болгон бууруулсантай холбогдуулан тус зээлийн барьцаанд “Хөсөг Трейд” ХК-ийн улсын бүртгэлийн Э-2205002334, нэгж талбарын 1681600482 дугаартай газар болон улсын бүртгэлийн Ү-2205011243 дугаартай үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.

2. “Милко” ХХК-ийн “Хаан Банк”-наас авч буй эргэлтийн хөрөнгийн зориулалттай 4,737,600,000 /дөрвөн тэрбум долоон зуун гучин долоон сая зургаан зуун мянган/ төгрөгийг 52 сарын хугацаатай, жилийн 15 хувийн хүүтэй, эхний 4 сар зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэй зээлийн барьцаанд энэхүү тогтоолын 1-д дурдсан хөрөнгүүдийг мөн барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан газар болон үл хөдлөх хөрөнгө барьцаалах хэлцэл нь их хэмжээний хэлцэл болохыг дурдсугай.

4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу барьцааны гэрээ болон бусад холбогдох бүхий л баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /М.Эрдэнэсүх/-д олгосугай.

5. Милко ХХК-ийн дээр дурдсан зээлүүдийн барьцаанд тавих Хөсөг трейд ХК-ийн газар болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг энэхүү тогтоолын хавсралт №1-д заасначаар тогтоож барьцаалахыг зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: С.БОЛОР

ГИШҮҮД: Ж.ГАНТОГТОХ

Г.МАРГАД

ХӨСӨГ ТРЕЙД ХК
KHUSUG TRADE JSC
9022010958
2037467 СБД 17610
УЛААНБААТАР ХОТ

С.БАТ-ӨЛЗИЙ

С.ЖАВЗАН-ОРЛОМ

Д.БАДАМ

Ц.ДАМЖИН

Т.ӨЛЗИЙБҮРЭН

Р.ГАНСҮХ

**Хөсөг трейд ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн**
**2024 оны 12 сарын 20-ны өдрийн 08 тоот тогтоолын хавсралт №01**

| № | Товч тайлбар | Байршил | Талбайн хэмжээ, м.кв | Улсын бүртгэл, гэрчилгээний дугаар | Эзэмшил | Барьцааны зүйлийн ЭТҮ | ЭТ% | Зах зээлийн үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Контор, авто үйлчилгээ | БГД 20-р хороо, ТЭЦ-3, баруун талд | 8,728 | Ү-2205011243 | Хөсөгтрейд ХХК | 7,792,540,800 | 60% | 12,987,568,000 |
| 2 | Газар | | 53,329 | Э-2205002334 | | 2,107,802,800 | 40% | 5,269,507,000 |